

"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар № 01.

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах
зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:


1. "Дарханы дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг "Сайн" гэж үнэлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.

2. Компанийн 2023 оны зорилтот түвшнийг биелүүлэх, өртөг зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, санхүү, төлбөрийн чадварыг сайжруулах, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮННИЙ ЯАМЫГ

ТӨЛӨӨЛЖ:


Н.ТАВИНБЭХ
УХА0558

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:


Ц.БАЯР-ЭРДЭНЭ
6098169 1118262983

**"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ"
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар №. 02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
ажлын тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. "Дарханы дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааг "Сайн" гэж дүгнэсүгэй.


2. Компанийн тавигдсан зорилтыг ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах,
үйл ажиллагааг эрчимжүүлэн хариуцлагатай, үр дүнтэй, санаачилгатай ажиллахыг
Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:



"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар № 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны
зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 84 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дарханы дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.


2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын болон Аудитын хороодод тус тус даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ


ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ



“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит
хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн
2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын
03. дугаар тогтоолын хавсралт



“ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр төрөл	2023 оны төлөвлөгөө /мян.төг/
1	-Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн	10
	-Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын цалин	12,150.0
	-Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин	92,400.0
	-Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын цалин	10,950.0
2	Цалингийн сан	115,500.0
3	Нийгмийн даатгалын шимтгэл	16,747.5
4	Томилолтын зардал /шатахуун/	240.0
5	Бичиг хэрэг	2,304.0
6	Хурал зохион байгуулах зардал	11,340.00
	ДҮН	146,131.5

"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар № 04

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны
ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6, 47.1.1-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дарханы дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компани нь 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлангаар алдагдалтай ажилласан бөгөөд компанийн эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр дутагдаж төлбөрийн чадвар буурах тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ

ТӨЛӨӨЛЖ:



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:



"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар №.05

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой
нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 84 дүгээр зүйлийн 84.4.2 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх түр журам"-ын 2.7, 2.8, 2.9 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/77 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дарханы дулааны цахилгаан станц" Төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг 78 оноор "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

2. Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатайгаар байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад удирдамж болгосугай.

3. Засгийн газраас дэвшүүлсэн хэмнэлтийн бодлогод нийцүүлэн өртөг зардлыг бууруулах, дулаан, цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, өр, авлагыг барагдуулах, үр ашгийг дээшлүүлэх, талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг гүйцэтгэх захирал (М.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:



"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар №.06

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дарханы дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийн өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг "Дарханы дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Н.ТАВИНБЭХ


ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Ц.БАЯА-ЭРДЭНЭ

6098169 1118262983

“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит
хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны
05 дүгээр сарын 02-ны өдрийн хурлын 06 дугаар
тогтоолын тогтоолын хавсралт



“ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРМИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

1.4. “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компани нь хэлбэрийн хувьд хувьцаат, төрлийн хувьд хаалттай компани байна. гэж нэмж оруулах;

1.4. “Компани нь 100 хувь төрийн өмчит хувьцаат компани байна. Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас олгосон төрийн байгуулга байх бөгөөд хувьцааны 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар тус тус эзэмшинэ” гэснийг 1.5 дахь заалт болгож “Компани нь 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд компанийн нийт хувьцааны 66 хувийн төлөөллийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 34 хувийн төлөөллийг төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх;

1.5. “Компанийн төлөөлөгчийн газрыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Улаанбаатар хотод байгуулж болно. Төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна” гэснийг хасах;

4.4 “Компани алдагдалтай ажилласан тохиолдолд ногдол ашиг хуваарилж болохгүй” гэснийг хасах;

4.5 “Компани эргүүлэн авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй” гэснийг хасах;

7.3 дахь заалт болгож “Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн эмблем бүхий тэмдэгтэй байна” гэж нэмэх;

7.3 дахь заалтыг 7.4 дэх заалт болгож өөрчлөх;

7.3.1 дэх заалтыг 7.4.1 дэх заалт болгож өөрчлөх;

7.3.2 дахь заалтыг 7.4.2 дахь заалт болгож өөрчлөх;

7.3.3 дахь заалтыг 7.4.3 дахь заалт болгож өөрчлөх;

7.3.4 дэх заалтыг 7.4.4 дэх заалт болгож өөрчлөх;

7.3.5 дахь заалтыг 7.4.5 дахь заалт болгож өөрчлөх;

7.3.6 дахь заалтыг 7.4.6 дахь заалт болгож өөрчлөх;

7.3.7 дахь заалтыг 7.4.7 дахь заалт болгож өөрчлөх;

7.3.8 дахь заалтыг 7.4.8 дахь заалт болгож өөрчлөх;

7.3.9 дэх заалтыг 7.4.9 дэх заалт болгож өөрчлөх;

7.3.10 дахь заалтыг 7.4.10 дахь заалт болгож өөрчлөх;
7.3.11 дэх заалтыг 7.4.11 дэх заалт болгож өөрчлөх;
7.3.12 дахь заалтыг 7.4.12 дахь заалт болгож өөрчлөх;
7.3.13 дахь заалтыг 7.4.13 дахь заалт болгож өөрчлөх;
7.3.14 дэх заалтыг 7.4.14 дэх заалт болгож өөрчлөх;
7.3.15 дахь заалтыг 7.4.15 дахь заалт болгож өөрчлөх;
7.3.16 дахь заалтыг 7.4.16 дахь заалт болгож өөрчлөх;
7.3.17 дахь заалтыг 7.4.17 дахь болгож өөрчлөх;
7.3.10 "Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах хөлсөөр ажиллах гэрээний нөхцөл, түүнд олгох үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах шийдвэр гаргах" гэснийг 7.4.10. захь заалтаар "компанийн гүйцэтгэх захиралтай түүнд олгох үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тодорхойлсон онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах" гэж өөрчлөх
7.3.11 "компанийн аудитын байгууллагыг сонгож түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах" гэснийг 7.4.11 дэх заалтаар "эрх бүхий байгууллагаас сонгосон аудитын байгууллагын компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах" гэж өөрчлөх;
7.7. "Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тэмдэглэл, тогтоол нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно" гэснийг "Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тэмдэглэл, тогтоол нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно" гэж өөрчлөх;
7.17. "Аудитын хорооны дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна" гэснийг "Аудитын хорооны дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд санхүү эдийн засгийн мэргэжилтэй байна" гэж өөрчлөх;
7.18. "Аудитын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна" гэж нэмж оруулах;
7.17.1 дэх заалтыг гэснийг 7.18.1 дэх заалт болгож өөрчлөх;
7.17.2. "дотоод хяналтын албаны удирдлага, ажилтнуудыг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах" гэснийг 7.18.2 дахь заалт болгож "дотоод аудиторыг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж шийдвэр гаргуулах" гэж өөрчлөх;
7.17.3. аудитын байгууллагыг сонгох, тэдний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитын байгууллагад санал өгөх /чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитын байгууллагатай байгуулах гэрээнд

тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ” гэснийг 7.18.3 дахь заалт болгож “хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитын байгууллагад санал өгөх /ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ/” гэж өөрчлөх өөрчлөх;

7.17.4 дэх заалтыг 7.18.4 дэх заалт болгож өөрчлөх;

7.17.5 дахь заалтыг 7.18.5 дахь заалт болгож өөрчлөх;

7.17.6.”Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс шилжүүлсэн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг” гэснийг 7.18.6 дахь заалт болгож “компанийн дүрэмд заасан болон төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал” гэж өөрчлөх;

өөрчлөх;

7.18 дахь заалтыг 7.19 дэх заалт болгож өөрчлөх;

7.18.1 дэх заалтыг 7.19.1 дэх заалт болгож өөрчлөх;

7.18.2 дахь заалтыг 7.19.2 дахь заалт болгож өөрчлөх;

7.18.3. дахь заалтыг 7.19.3 дахь заалт болгож өөрчлөх;

7.18.4 дэх заалтыг 7.19.4 дэх заалт болгож өөрчлөх;

7.18.5.”Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах” гэснийг 7.19.5 дахь заалт болгож “гүйцэтгэх захиралтай байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг боловсруулах” гэж өөрчлөх;

7.18.6 дахь заалтыг 7.19.6 дахь заалт болгож өөрчлөх;

7.18.7 дахь заалтыг 7.19.7 дахь заалт болгож өөрчлөх;

7.18.8 дахь заалтыг 7.19.8 дахь заалт болгож өөрчлөх;

7.19 дэх заалтыг 7.20 дахь заалт болгож өөрчлөх;

7.19.1 дэх заалтыг 7.20.1 дэх заалт болгож өөрчлөх;

7.19.2 дахь заалтыг 7.20.2 дахь заалт болгож өөрчлөх;

7.19.3 дахь заалтыг 7.20.3 дахь заалт болгож өөрчлөх;

7.19.4 дэх заалтыг 7.20.4 дэх заалт болгож өөрчлөх;

7.19.4.”Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс шилжүүлсэн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг” гэснийг 7.20.4 дахь заалт болгож “компанийн дүрэмд заасан болон төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал” гэж өөрчлөх;

7.20 дахь заалтыг 7.21 дэх заалт болгож өөрчлөх;

7.21 дэх заалтыг 7.22 дахь заалт болгож өөрчлөх;

7.22 дахь заалтыг 7.33 дахь заалт болгож өөрчлөх;

8.1.”Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлага нь хувь хүн байх бөгөөд уг этгээд компанийн гүйцэтгэх захирал байна” гэснийг “Гүйцэтгэх удирдлага нь хувь хүн байх бөгөөд компанийн гүйцэтгэх захирал байна” гэж өөрчлөх;

8.2.Гүйцэтгэх захирлыг түүнтэй байгуулах гэрээний үндсэн дээр Төлөөлөн удирдах зөвлөл байгуулна” гэснийг “Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн удирдах зөвлөл томилно” гэж өөрчлөх;

8.3.”Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж түүний дарга гарын үсэг зурна. Гэрээнд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна” гэснийг “Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна” гэж өөрчлөх;

8.4.”Гүйцэтгэх захирал нь өөрт олгосон эрхийн хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна” гэснийг 8.6 дахь заалт болгож өөрчлөх

8.5 дахь “Гэрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж түүний дарга гарын үсэг зурна. Гэрээнд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна” гэж өөрчлөх;

8.5.”Гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх асуудлыг төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ” гэснийг “Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захирлын хооронд байгуулах онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ нь нэг жилийн хугацаатай байна. Гэрээнд заасан санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт бүрэн хангагдсан байна” гэж өөрчлөх;

8.6 Гүйцэтгэх захирлыг бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл хэдийд ч гаргаж болно гэснийг 8.7 дахь заалт болгон “Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг цуцлах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл хэдийд ч гаргаж болно” гэж өөрчлөх;

8.7.Гүйцэтгэх захирал нь компанийн Дэд захирал бөгөөд ерөнхий инженер, Төлөвлөлт санхүү бүртгэлийн хэлтсийн дарга /ерөнхий нягтлан бодогч/-ийг томилохдоо Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөнө” гэснийг 8.8.дахь заалт болгож “Гүйцэтгэх захирал нь компанийн Ерөнхий инженер, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга /ерөнхий нягтлан бодогч/-ийг томилохдоо Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөнө” гэж өөрчлөх;

8.8 дахь заалтыг 8.9 дэх заалт болгож өөрчлөх;

8.8.1.Менежментийн ур чадвартай, 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажил гүйцэтгэж байсан, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, удирдлагын зохих дадлага туршлагатай, эрчим хүчний инженер, эсхүл эдийн засгийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх” гэснийг 8.9.1 дэх заалт болгож “удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил, тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, эрчим хүчний инженер /0713 цахилгаан, эрчим хүч/, эсхүл менежмент ба удирдахуй /0413/ чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх” гэж өөрчлөх;

8.8.2 дахь заалтыг 8.9.2 дахь заалт болгож өөрчлөх;

8.8.3 дахь заалтыг 8.9.3 дахь заалт болгож өөрчлөх;

8.8.4 дэх заалтыг 8.9.4 дэх заалт болгож өөрчлөх;
8.9 дэх заалтыг 8.10 заалт болгож өөрчлөх;
8.10 дахь заалтыг 8.11 дэх заалт болгож өөрчлөх;
8.11 дэх заалтыг 8.12 дахь заалт болгож өөрчлөх;
8.11.1 дэх заалтыг 8.12.1 дэх заалт болгож өөрчлөх;
8.11.2 дахь заалтыг 8.12.2 дахь заалт болгож өөрчлөх;
8.11.3 дахь заалтыг 8.12.3 дахь заалт болгож өөрчлөх;
8.11.4 дэх заалтыг 8.12.4 дэх заалт болгож өөрчлөх;
8.11.5 дахь заалтыг 8.12.5 дахь заалт болгож өөрчлөх;
8.11.6 дахь заалтыг 8.12.6 дахь заалт болгож өөрчлөх;
8.11.7 дахь заалтыг 8.12.7 дахь заалт болгож өөрчлөх;
8.11.8 дахь заалтыг 8.12.8 дахь заалт болгож өөрчлөх;
8.11.9 дэх заалтыг 8.12.9 дэх заалт болгож өөрчлөх;
8.11.10 дахь заалтыг 8.12.10 дахь заалт болгож өөрчлөх;
8.11.11 дэх заалтыг 8.12.11 дэх заалт болгож өөрчлөх;
8.11.12 дахь заалтыг 8.12.12 дахь заалт болгож өөрчлөх;

9.1."Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, Дэд захирал бөгөөд ерөнхий, Төлөвлөлт санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, /ерөнхий нягтлан бодогч/, Инженерийн албаны дарга, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Хангамжийн хэлтсийн дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно" гэснийг .Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ерөнхий инженер, техник, санхүү, захиргаа, хяналт хариуцсан нэгжийн дарга нар болон дотоод аудитор, гэрээ хэлэлцэл байгуулахад шууд болон шууд бусаар оролцдог инженер техникийн ажилтан, албан тушаалтан, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно" гэж өөрчлөх;

10.5. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ" гэснийг "Дотоод хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон дотоод аудитор хэрэгжүүлнэ" гэж өөрчлөх;

10.6."Дотоод аудиторын хийх ажлын төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо баталж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгч, шаардлагатай тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна" гэж нэмэх;

10.6. Дотоод хяналтын алба нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан явцыг үнэлэн, сайжруулах зөвлөмж өгөх мэдлэг туршлагатай байх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна" гэснийг 10.7 дахь заалт болгон "Дотоод аудитор нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, засаглалын үйл явцыг үнэлэн, сайжруулах

зөвлөмж өгөх мэдлэг туршлагатай байх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан “Дотоод аудиторын ажиллах журам”-ын дагуу үйл ажиллагаагаа явуулна” гэж өөрчлөх;

10.7. Дотоод хяналтын алба нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж, гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, энэхүү дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолд нийцэж байгаа эсэхийг хангаж ажиллана” гэснийг 10.8 дахь заалт болгон “Дотоод аудитор нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж, гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, энэхүү дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолд нийцэж байгаа эсэхийг хангаж ажиллана” гэж өөрчлөх;

10.8. “Дотоод хяналтын алба нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад өгөх, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, мэдээлэх үүрэгтэй” гэснийг 10.9 дэх заалт болгож “Дотоод аудитор нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад өгөх, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, мэдээлэх үүрэгтэй” гэж өөрчлөх;

10.9 “Компанийн хөндлөнгийн аудитыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгосон тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар хийлгэнэ” гэснийг 10.10 дахь заалт болгож Компанийн хөндлөнгийн аудитыг Төрийн аудитын тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар хийлгэнэ” гэж өөрчлөх;

10.10 дахь заалтыг 10.11 дэх заалт болгож өөрчлөх;

12.2. Компанийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байх бөгөөд түүнийг Сангийн яамны зөвшөөрөлтэйгөөр гүйцэтгэх захирал томилж чөлөөлнө” гэснийг “Компанийн Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга (ерөнхий нягтлан бодогч) нь мэргэшсэн нягтлан бодогч байна” гэж өөрчлөх;